



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар Б/16

Чингис хот

**С.Ган-Эрдэний албан тушаалын ангилал,  
зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.1.10, 11.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын ангилал, зэрэглэл”, 2019 оны 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан Сагадйн Ган-Эрдэний албан тушаалын ангилал, зэрэглэлийг ТҮ-7-1-ээр шинэчлэн тогтоосугай.

2. С.Ган-Эрдэний сарын үндсэн цалинг ТҮ-7-1 шатлалаар тогтоон, 674306 /зургаан зуун далан дөрвөн мянга гурван зуун зургаа/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030076